



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/14

Зуунмод

“Цагаан сар- 2024” үзэсгэлэн
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сар шинийн баярын өдрийг угтаж хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс хэрэглэгчдэд шууд борлуулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдааг 2024 оны 01 дүгээр сарын 25,26,27-ны өдрийг дуустал Зуунмод суманд Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Спорт заал, гадна талбайд тус тус зохион байгуулсугай.

2.“Цагаан сар 2024 ” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Н.Гантулга

(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Н.Доржбалжид

(Цагдаагийн газрын Хэв журмын тасгийн дарга, дэд хурандаа)

Э.Баярбат

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлчилгээний албаны дарга)

Д.Намсрайноров

(Монгол туургатан театрын дарга)

А.Өнөржаргал

(УБЦТС Зуунмод ХҮТөв)

Б.Батболд

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Э.Ганхуяг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн ахлах ажилтан)

А.Шаравнямбуу

(Хот тохижуулах газрын дарга)

Х.Түвшинжаргал

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга)

М.Туяа

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)

С.Ганчимэг

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн албаны дарга)

М.Ганчимэг

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын албаны дарга)

Б.Болортуяа

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Ахлах мэргэжилтэн)

Б.Түмэнжаргал

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын Улсын байцаагч)

Х.Түвшинсанаа	(Хүнс, хөдөө ахуйн газрын Хяналтын Улсын байцаагч)
Б.Цэрэнгомбо	(Хүнс, хөдөө ахуйн газрын Хяналтын Улсын байцаагч)
С.Тулга	(Хүнс, хөдөө ахуйн газрын мэргэжилтэн)
Н.Ган-Адъяа	(Хүнс, хөдөө ахуйн газрын мэргэжилтэн)
Н.Оюумаа	(Хүнс, хөдөө ахуйн газрын мэргэжилтэн)
Г.Цоггэрэл	(Хүнс, хөдөө ахуйн газрын мэргэжилтэн)
А.Оюунбаяр	(Хүнс, хөдөө ахуйн газрын мэргэжилтэн)
Б.Уянга	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
С.Саранмандал	(Хүнс, хөдөө ахуйн газрын мэргэжилтэн)
Г.Уянга	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Б.Оюунжаргал	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн Улсын байцаагч)
Б.Ариунжаргал	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн шинжээч)
О.Мягмаржав	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Ж.Дорж	(Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн)
А.Батхонгор	(Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн)
	(Сумын Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	
Ж.Батчимэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Б.Лхагвасүрэн	(Хүнс, хөдөө ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга)

3.Үзэсгэлэн худалдаанд оролцогч үйлдвэрлэл эрхлэгчдийг зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулж оролцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4."Цагаан сар 2024" үзэсгэлэн арга хэмжээг нарийвчилсан төлөвлөгөөтэй, аймаг орон нутгаа сурталчлан, иргэд олон түмний амжилт бүтээлд уриалан зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүд, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах нөхцөлийг хангаж, худалдаа үйлчилгээний байр талбайгаар ханган хамтран ажиллахыг Гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга (М.Буянхишиг)-д даалгасугай.

6.Үзэсгэлэн худалдааны өмнө цалин тэтгэвэр, тэтгэмж олгох зохион байгуулалтын арга хэмжээ авахыг өмчийн бүх хэвшлийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

7.Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР